

МОНГОЛЬСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК  
Институт истории и  
этнологии



РОССИЙСКАЯ  
АКАДЕМИЯ НАУК  
Институт восточных  
рукописей



МЕЖДУНАРОДНАЯ  
АССОЦИАЦИЯ  
МОНГОЛОВЕДОВ



# КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

## V

Международная конференция  
при поддержке Президента Монголии



19-21 апреля 2021 г. Санкт-Петербург

Сборник докладов

Санкт-Петербург- Улан-Батор  
2023

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Ответственный редактор:** Академик С. Чулуун  
**Редакторы-составители:** доктор филол. наук И.В.Кульганек  
доктор (Ph.D) Н.Хишигт  
кандидат филол. наук Д.А.Носов

**Культурное наследие монголов:** Рукописные и архивные собрания. Сборник докладов V международной научной конференции. 19-21 апреля 2021 г. Санкт-Петербург, Россия. СПб.-УБ., 2023 г. -...с.,

Сборник представляет собой собрание докладов V международной научной конференции "Культурное наследие монголов: рукописные и архивные собрания", организованной Институтом восточных рукописей РАН, Институтом истории и этнологии МАН и Международной Ассоциацией монголоведов в г.Санкт-Петербург, 19-21 апреля 2021 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Институт восточных рукописей РАН, 2023 г

© Институт истории и этнологии МАН, 2023 г.

© Международная ассоциация монголоведов, 2023 г

МОНГОЛ УЛСЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИ  
Түүх, угсаатны зүйн  
хүрээлэн



ОХУ-ЫН  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИ  
Дорно дахины гар  
бичмэлийн хүрээлэн



ОЛОН УЛСЫН МОНГОЛ  
СУДЛАЛЫН ХОЛБОО



# МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

## V

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор  
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2021 оны 4 сарын 19-21  
Санкт-Петербург хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург- Улаанбаатар  
2023

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Хариуцлагатай редактор:** Академич С.Чулуун  
**Эмхтгэгч-редактор:** Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек  
Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт  
Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Д.А.Носов

**Монголчуудын соёлын өв:** гар бичмэл ба архивын баримтын цуглуулга - V. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2021 оны 4 дүгээр сарын 19-21. ОХУ, Санкт-Петербург хот. Санкт-Петербург-Улаанбаатар., 2023 г. ... тал.

Тус эмхэтгэлийг Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Олон улсын Монгол судлалын холбооноос 2021 оны 4 дүгээр сарын 19-21-нд ОХУ-ын Санкт-Петербург хотноо хамтран зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 5 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, угсаатны зүй, улс төр, соёлд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2023 г

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2023 г

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2023 г

MONGOLIAN ACADEMY  
OF SCIENCES  
Institute of History and  
Ethnology



RUSSIAN ACADEMY OF  
SCIENCES  
Institute of Oriental  
Manuscripts



INTERNATIONAL  
ASSOCIATION FOR  
MONGOL STUDIES



# CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

**V**

**International Conference  
Under the Patronage of the President of Mongolia**



April 19-21, 2021. St. Petersburg

Proceedings

St. Petersburg - Ulaanbaatar  
2023

ННА 63.4  
ДАА 930.1  
М-694

**Edited and compiled by**

acad. S.Chuluun  
D.Sc.(Philology) I.V.Kulganek,  
Ph.D (History) N.Khishigt,  
Cand.Sc.(Philology) D.A.Nosov

**Cultural heritage of the Mongolis:** manuscripts and archival collections. Papers of the V International Conference, April 19-21, 2021. St.Petersburg. St.Petersburg -Ulaanbaatar 2023, .... pages.

This is a collection of papers, presented at the Fifth International Conference organized by the the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in St. Petersburg on April 19-21, 2021.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN-9919-9975-3-3

DOI 10.48612/IVRRAN/txh8-x7kh-v3fx

© Institute of Oriental Manuscripts RAS, 2023 r

© Institute of History and Ethnology MAS, 2023 r.

© International Association for Mongol Studies, 2023 r

## ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ /

## ӨМНӨХ ҮГ / ПРИВЕТСТВИЕ

|  |    |
|--|----|
| Приветствие директора Института восточных рукописей РАН,<br>член-корреспондента РАН И.Ф.Поповой  | 11 |
| Монгол улсын ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д. Рэгдэлийн мэндчилгээ                               | 13 |
| Приветствие генерального секретаря международной ассоциации<br>монголоведов, академика С.Чулууна | 15 |
| Монгол улсын Их хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд<br>Л.Энх-Амгалангийн мэндчилгээ    |    |
| Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч<br>Д.Сумъяабазарын мэндчилгээ           |    |

## ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

*Г. Алтансүх.*

Аноним Шибани Нāме дахь монгол хүний нэрийн зарим асуудалд

*Э. Баярчимэг*

Лхаарамба Агваандандарын найруулсан “Сарны гэгээн гэрэл” хэмээх дохионы бичгийн нэгэн хувилбарын тухай

*К. И. Бикмаева*

Национальные программы по монгольской письменности (монгол бичгийн үндэсний хөтөлбөр) как один из основных документов в области языковой политики монголии

*Л. Ганбат*

Ибн Арабшах-ийн “Acāibu’l makdūr” зохиолд нүүдэлчдийн байлдах арга, бодлогын тухайд өгүүлсэн нь

*Л. С. Дампилова*

Жанровое разнообразие архивных материалов Монгольской экспедиции 1967 года

*И. М. Захарова, М. В. Мандрик*

Экспедиции М.Д. и Н.Д. Бутиных 1870 и 1881 гг. в Китай

*И. В. Кульганек, Н. В. Захарова*

Фотографии о монголии и монголах в Институте восточных рукописей РАН

*Э. Мөнхцэцэг*

Монгол улсын Үндэсний Номын сан дахь нэгэн монгол-манж толь бичгийн тухай

*Б. Нацагдорж, О. Оюунжаргал*

“Хүрээний хэргийн зүй (庫倫事宜)” хэмээх сурвалжийн тухай

*Д. А. Носов*

Россыпи документов В. А. Казакевича: полевой дневник 1925 г.

*Р. Ю. Почекаев*

Правовые воззрения монголов в пословицах и поговорках

*Э. Пүрэвжав*

Хэлмэгдсэн бүтээлүүд: 1938 оны V сарын 12-ны өдрийн акт бичиг

*Т. Д. Скрынникова*

Сакральность правителя и его ритуальные функции  
(По материалам анонимной Altan tobci)

*М. В. Федорова*

Этнографическая коллекция Д.Э. Ухтомского, привезенная из  
экспедиции в Северную Монголию (1910 г.)

*А. Д. Цендина*

Гадания на кубиках (по материалам квартиры-музея  
Ц.Дамдинсүрэна и коллекции Р.Отгонбаатара)

*Б.-Х. Б. Цыбикова*

Локальные особенности устных нарративов бурят о Шоно баторе

*С. Чулуун, Н. Хатанбаатар*

Берестяная грамота, обнаруженная из раскопок монастыря в  
Монгольском гоби

*Т. И. Юсупова*

Монгольский ученый комитет в отзывах российских исследователей

РЕЗОЛЮЦИЯ

СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

ЗОХИОГЧДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ



DOI 10.48612/IVRRAN/uxrp-anh4-dn6r

Г.Алтансүх

## АНОНИМ ШИБАНИ НĀМЕ ДАХЬ МОНГОЛ ХҮНИЙ НЭРИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Судалгааны дүнгээс үзэхэд энэ сурвалжид гар бичмэлд ойролцоо зурлагатай үсгүүдийг андуурсны зэрэгцээ хоорондоо нэг цэгийн ялгаатай бичигддэг үсгүүдийг мөн андуурч уншсанаас үүдэлтэй алдаанууд нийтлэг байна. Тиймээс Аноним Шибани нāме-г Чингис хаан ба түүний өвөг дээдсийн нэрийн талаар өөр хувилбарыг өгч буй сурвалж гэж үзэх боломжгүй юм.

Шибани нāме сурвалжийн зохиогч, хуулан бичигч нар перс сурвалжуудад байгаа монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг алдаж уншсан, түүний цэг дуслыг андуурсан алдаанууд гаргаснаас үүдэлтэй тус сурвалжийн судалгаанд зарим ойлгомжгүй байдлууд үүсэж, тодорхой бэрхшээл тулгардаг. Энэ нь Монголын түүх, монгол хүний нэрийн тогтолцоог сайн мэдэхгүй залуу судлаачдын хувьд тодорхой бэрхшээл болдог. Тиймээс энэ сурвалжид тэмдэглэгдсэн монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг Судрын чуулган болон Монголын нууц товчоон зэрэг сурвалжтай тулган нягтлах шаардлагатай байна.

*Түлхүүр үгс: нэр судлал, нэр, оноосон нэр, газрын нэр, овгийн нэр*

G.Altansukh

## ON THE SOME ISSUES OF MONGOLIAN PERSONAL NAMES IN ANONYMOUS SHIBANI NĀME

*According to the research results, mistakes caused by misreading of letters with close strokes as well as letters that differ by one point from each other are common in handwriting. Therefore, the Anonymous Shibani nāme is cannot be considered as a source providing an alternative version of the names of Genghis Khan and his ancestors. Some ambiguities arise in the research of this source, caused by the fact that the scribes who wrote the Shibani nāme source misread the name of the Mongolian person, the name of the land, the name of the tribe in the Persian sources, and confused the punctuation. In particular, it is a problem for young researchers who are not know with Mongolian history and the name system of Mongolian persons. Therefore, it is necessary to verify the names of*

*Mongolian persons, names of places, and tribes recorded in this source with sources such as the Jami'ut-tawarikh and The Secret History of the Mongols.*

*Key words: onomastic, name, given name, place name, family name.*

Цагадай хэл бол түрэг төрлийн хэлүүдээс Дундад Азийн бүлэгт хамаардаг, XV зууны эхнээс XX зууны эхэн хүртэл идэвхитэй хэрэглэгдэж байсан утга зохиолын хэл юм. Өнөөгийн түрэг хэлүүдээс Өзбек хэл ба Шинэ уйгур хэлтэй ойролцоо. Судлаачдын бичсэнээс тоймлон үзвэл, Дундад Азид монголчуудын засаглал тогтохоос өмнө хорезм түрэг хэл, кипчак түрэг хэл гэсэн үндсэн хоёр салбар аялгуу байжээ. Харин монголчуудын байлдан дагууллын дүнд тэр газар нутагт Цагадайн улс байгуулагдсанаар кипчак, хорезм зэрэг түрэг хэлний салбар аялгуунууд ижилсэн нийлж утга зохиолын шинэ хэл үүссэн нь цагадай хэл юм.

Цагадай хэлээр бичиж үлдээсэн Монголын түүхийн сурвалжууд нэлээдгүй байдаг. Гэвч тэдгээр сурвалжийн судалгаанд тулгарч байдаг нэг асуудал нь монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг ихээхэн зөрүүтэй бичсэн явдал юм. Энэ нь тухайн сурвалжийн зохиогчийн болон хуулан бичээч нарын хариуцлага, ур чадварын асуудал мөн боловч тодорхой түүхэн нөхцөл шалтгаантай байдаг.

Цагадайн улс задран унахдаа эхлээд Мавераннахр болон Моголистан [Талас голын зүүн талын нутаг өөрөөр хэлбэл Туркестан болон Сэмирэч] гэсэн хоёр хэсэгт хуваагдсан байна. 1360 онд Туглугтөмөр буцаан нэгтгэсэн боловч 1363 онд түүнийг нас барсны дараахан Цагадайн улсын үндсэн хэсэг эмир Төмөрийн мэдэлд оржээ [Grousset 1980. pp. 397-420]. 1370 оны 04 сарын 10 өдөр Балх хотод Төмөр өөрийгөө хаан өргөмжилснөөр түүхэн зохиолуудыг перс хэлээр бичих болов. Гэвч Эмир Төмөрийн байлдан дагуулаар байгуулсан улс XVI зууны эхэн үед [1507] задран унахтай зэрэгцэн Чингис хааны ууган хөвүүн Жүчи ханы шууд удмын Мухаммед Шибан хан Мавернахрыг эзлэн авч өөрийн улсыг байгуулсан байна. Тэгээд Шибан хан өөрийнхөө ялалтын түүхийг үр хойчистоо зориулан цагадай хэлээр бичих зарлиг буулгажээ. Энэ зарлигийн дагуу бичсэн түүхэн зохиолуудын нэг нь бидний сонирхон буй Шибани наме мөн юм.

Шибани наме хэмээн нэрлэдэг хэд хэдэн сурвалж байна. Үүний нэг нь түүх бичлэгт аноним буюу зохиогч нь тодорхойгүй Шибани наме хэмээн нэрлэдэг түүхэн сурвалж юм. Энэ сурвалжийн нэг гар бичмэл эдүгээ ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнд С-139 бүртгэлийн дугаартай хадгалагдаж байна. Тус сурвалжийг хэн,

хэзээ бичсэн тухай тодорхой мэдээлэл байхгүй. Гэхдээ Абулхайр ханы ураг удмыг 1530 он хүртэл бичсэнээс үзвэл XVI гучаад оноос хойш бичсэн нь лавтай юм. Гар бичмэлийн төгсгөл хэсэгт бичсэн газрыг нь *temmetü al-risale šerife fi valayit buhara* “Энэхүү жижиг номыг Бухар мужид бичиж төгсгөв.” хэмээн заажээ.

XVI зууны үе гэхэд Мавернахр болон Туркестаны бүс нутагт монгол хэлний хүч нөлөө буурч, монгол хэл, Монголын түүхийг сайн мэдэх хүн цөөрч байв. Тиймээс XVI зууны эхэн үеэс цагадай хэлээр бичих болсон түүхийн зохиолуудад өмнөх үеийн монголчуудын хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг буруу бичих нь нэлээд түгээмэл болжээ. Энэ байдлыг Абул Гази Бахадур хан “Шежере-и Турк” зохиолдоо “... Энэ зохиолыг бичихэд Судрын чуулган надад байсан. Түүнээс гадна Чингис хааны намтар түүхэнд холбогдох 17 ном байна. Тэдгээрт тулгуурлан номоо бичлээ. Судрын чуулган бичигдээд 372 жил өнгөрчээ. Миний гарт түүний 20-30 эх байх боловч тэд бүгдээр хуулан бичигч нарын зүгээс оруулсан ялгаа, алдаа ихтэй байна. Энэхүү түүхэн зохиолын уул, усны төдийгүй хүний нэр монгол хэлээр эсвэл түрэг хэлээр бичигджээ. Харин хуулан бичигч нар ихэвчлэн перс эсвэл тажик хүмүүс байдаг. Тэд монгол хэл, түрэг хэлийг огт мэдэхгүй. Тиймээс монгол нэрүүдийг тэдэнд 10 өдөр заасан ч огт ойлгохгүй юм. Тиймээс тэд энэ номыг яаж ч зөв хуулан бичих билээ” хэмээн тодорхойлсон байдаг [Ebu'l-Gazi Bahadır Han 2009.s. 38-39]. Тоймлон хэлбэл, XVI-XVII зууны үед цагаадай хэлээр бичигдсэн түүхэн сурвалжуудын тулгуур эх хэрэглэгдэхүүн нь Судрын чуулган тэргүүтэй перс сурвалжууд байсан боловч тэдгээр перс сурвалжуудад буй монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг зөв хуулан бичих нь ихээхэн хүчир болсон байжээ.

Бидний хэлэлцэн буй Шибани наме бол XVI зууны дунд үед монгол хэл сайн мэдэхгүй хүний бичсэн түүхэн зохиол бөгөөд Абул Гази Бахадур ханы тодорхойлсон тус алдаа мадгийн тод жишээ болохуйц сурвалж юм.

Шибаны наме сурвалж нь үндсэн гурван хэсэгтэй:

1. Адамаас эхлээд Чингис хааны үе хүртэлх хэсэг
2. Хонгират иргэний түүхэнд холбогдох хэсэг
3. Шибан ханы түүхийн хэсэг

Эдгээрээс нэгдүгээр хэсэгт тэмдэглэгсэн монгол хүний нэрүүдэд нэлээд алдаа гарсан учир энэ илтгэлийн хүрээнд нэгдүгээр хэсэгт буй монгол хэлний оноосон нэрүүдэд гарсан нийтлэг алдаа, түүнээс урган гарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэх арга замын тухай товч өгүүлнэ.

**Хүний нэр:**

Зөрүүтэй бичсэн зарим нэрс

1. Эхэд لارم یتوق *Quti maral* хэмээн бичсэн байна [96a, 13]. Судрын чуулганд тус нэрийг لارم أوق *Qua maral* гэж бичсэн [Rešidüddin Fazlullah 1373, s.218] бол Монголын нууц товчоонд 騰格<sup>舌</sup>理額扯 *Qo'ai maral* хэмээн бичдэг [§ 1].

2. Эхэд тус нэрийн اىق یتوق *Otci qıyan* хэмээн бичжээ [96b, 01]. Харин Судрын чуулганд ناق یتوق *Bataci qa'an* гэж бичсэн байна [Rešidüddin Fazlullah 1373. s.218]. Монголын нууц товчоонд 巴塔赤罕 *Bataciqan* хэмээн бичсэн байдаг [§ 1, 2].

3. Эхэд انکیرا *Eriken* гэж бичсэн байна [99a, 11]. Монголын нууц товчоонд 抄真幹兒帖該 *Čaujin örtegei* хэмээн 2 удаа тэмдэглэжээ [§ 47(2)]. Түүний нэрийг Судрын чуулганд نیچۆاج *Ja'učin*, یاگتروه نیچۆاج *Ja'učin* гэж бичсэн байдаг [Rešidüddin Fazlullah 1373. s.238].

4. Эхэд وک گنس *Sing-kükürken* хэмээн бичсэн [106b, 09] бол Судрын чуулганд تىگىچ وک گنس *Čikü kürgen* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.160]. Монголын нууц товчоонд 赤古古<sup>舌</sup>列堅 *Čigü güregen* хэмээн бичсэн байна [§ 202].

5. Эхэд سمس یتوق *Semsa'uci* гэж бичжээ [96b, 04]. Судрын чуулганд тус нэрийг سمسو یتوق *Semsoči* хэмээн тодорхой бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.219] бол Монголын нууц товчоонд 掃鎖赤 *Semsoči* хэмээн бичжээ [§ 2].

6. Эхэд وىق سوب *Bosqin salci* хэмээн бичжээ [98a, 04]. Судрын чуулганд وىق سوب *Buqatu salaci* [Rešidüddin Fazlullah 1373. s.223], Монголын нууц товчоонд 不<sup>中</sup>忽秃撒<sup>鞞</sup>只 *Buqutu salji* хэмээн бичсэн байдаг [§ 42].

7. Эхэд وىق سوب *Qubañu merken* хэмээн бичсэн байна [96b, 02]. Энэ нэрийг Судрын чуулганд وىق سوب *Qoričar mergen* хэмээн бичдэг [Rešidüddin Fazlullah 1373. s.218] бол Монголын нууц товчоонд 豁<sup>舌</sup>里察兒箠兒干 *Qoričar mergen* хэмээн бичдэг [§ 2]. Энд Судрын чуулганд тэмдэглэгдсэн монгол хүний нэрийг уншихдаа үсэг, цэг тэмдэг зөрүүлэн уншсан нь илэрхий байна. Тухайлбал, وىق سوب нэрийн و үсгийг ʋ үсгээр андуурсан, ح үсгийг چ үсгээр андуурсан байгаа юм. Энэ нь Судрын чуулганы зарим эхэд энэхүү эгшиг ялгах тэмдэг тавиагүй байдагтай холбоотой.

8. Эхэд وىق سوب *Yuqun qataqi* хэмээн бичжээ [98a, 03]. Судрын чуулганд тус нэрийг وىق سوب *Buqun qataqi* гэж бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.183] бол Монголын нууц товчоонд 不<sup>中</sup>忽<sup>中</sup>合

塔吉 *Biqiqatagi* хэмээн бичсэн буй [§ 19]. Харин тус эхэд нэрийн эхний б үсгийн цэгийг андуурч уншсан бололтой байна.

9. Эхэд رجنزوب *Bozančar* хэмээн бичжээ [98a, 11]. Энэ нэрийг Судрын чуулганд رچنذوب *Bodunčar* хэмээн бичсэн байна [Rešidüddin Fazlullah 1373. s.227]. Харин Монголын нууц товчоонд 孛端察兒 *Bodončar* гэж бичдэг [§ 17]. Судрын чуулганы رچنذوب нэрийн ڊ үсэгний дээд талын эгшиг ялгах тэмдгийг цэгтэй андуурч уншсан бололтой.

10. Эхэд دوکؤا *Üküid* гэж бичсэн бол Судрын чуулганд энэ үгийг روکؤا *Buda üküir* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.241]. Судрын чуулган дахь нэрийн төгсгөлд буй ڎ үсгийг ڊ хэмээн андуурсан нь илэрхий байна. И.Березин харин Угудъ хэмээн уншжээ [Березнымъ 1849. с. XXXI].

11. Эхэд قاغوب نىکوا *Ökin buyaq* гэж бичсэн байна [99b, 9]. Монголын нууц товчоонд тус нэрийг 斡勤巴兒<sup>中合</sup> *Ökin-barqaq* гэж бичсэн [§ 48] бол Судрын чуулганд قاقرب نىکوا *Ökin barqaq* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.249]. Эхэд тус нэрийг ڎ үсгийг ڎ үсэгтэй андуурч бичсэн нь тодорхой байна.

12. Эхэд رداہ اتروب *Burta bahadır* гэж бичжээ [99b, 10]. Мөн тус сурвалжийн 29-9, 10-т رداہ انترب *Bartan bahadır* гэж бичсэн байна. Монголын нууц товчоонд тус нэрийг 把兒壇把阿秃兒 *Bartan ba'atur* гэсэн [§ 48] бол Судрын чуулганд رذائبَ نانترب *Bartan bahadur* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.268]. Мөн уг нэрийн ڎ үсгийг ڎ үсэгтэй андуурч бичсэн бололтой.

13. Эхэд نىكجونا نادوت *Töden-oncikin* хэмээн бичжээ [99b, 15]. Уг нэрийг Монголын нууц товчоонд 脫朶延斡<sup>楊</sup> 赤斤 *Tödö'en-o[t] cigin* хэмээн бичжээ [§ 48]. Судрын чуулганд نىگچتواناگوتوت *Tödügen otčgin* гэжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.249]. Уг эхэд ن үсгийг ن үсэгтэй андуурсан байна.

14. Эхэд نىكيب نىجوف *Fücin biki* хэмээн бичжээ [109b, 02]. Судрын чуулганд тус нэрийг نىجوق نىكيب *Qocin biki* [Rešidüddin Fazlullah 1373. s.161], Монголын нууц товчоонд 中豁真別乞 *Qojin beki* гэжээ [§ 165]. Энд нэрийн эхэн дэх ق үсгийг ف үсэгтэй андуурчээ.

15. Эхэд اوکنم وتق وى وقا *Aquuqutu möngür* гэж бичжээ [99b, 12]. Тус нэрийн Монголын нууц товчоонд 中忽秃<sup>黑</sup> 秃蒙古 *Qutuqtu-mönggür* хэмээн бичсэн [§ 48] бол Судрын чуулганд رلگنوم وثقوتوق *Qutuqtu möngler* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.249].

16. Эхэд тус нэрийг له مكرت *Terke-ehil* хэмээн бичсэн [106a, 03] Судрын чуулганд тус хүний нэрийг له مكرت *Terge emel* гэж бичсэн байдаг

[Rešidüddin Fazlullah 1373. s.386]. Харин Монголын нууц товчоонд 迭<sup>舌</sup>兒格額<sup>克</sup>箴<sup>勒</sup> *Dergek emel* хэмээн бичжээ [§ 141]. Энд Судрын чуулганы эх дахь м үсгийг о үсгээр андуурч бичсэн нь тодорхой байна.

### Сурвалж дотроо зөрүүтэй бичсэн нэрс

1. Эхэд энэ нэрийг хоёр янзаар бичсэн байна. Эхлээд نىم موتو<sup>د</sup> *Dutum min* хэмээн бичжээ [98b, 03]. Дөрвөн мөрний дараа نىم موتو<sup>د</sup> *Dutum menin* хэмээн бичсэн буй [98b, 07]. Судрын чуулганд энэ нэрийг мөн адил نىم موتو<sup>د</sup> *Dutum menen* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.227]. Монголын нууц товчоонд 箴年土敦 *Menen tudun* хэмээсэн байна [§ 45]. Энэ нэрийн хувьд Судрын чуулган дахь نىم موتو<sup>د</sup> нэрийн ن үсгийн доод талын эгшиг ялгах тэмдгийг хоёр цэг хэмээн андуурч уншсан бололтой.

2. Эхэд ىلبوق *Qubla*, ىلبوق *Qūbla*, ىلبوق *Qutla* гэх зэргээр бичжээ [100b, 08, 09]. Монголын нууц товчоонд тус нэрийг 忽圖刺 *Qutula* хэмээн бичдэг [§ 48] бол Судрын чуулганд ىلبوق *Qutula* гэж бичсэн байна [Rešidüddin Fazlullah 1373. s.249]. И.Березин эхийг дагаж *Гкубила Гкаан* хэмээн бичжээ [Березнымъ1849. с. XXXIII].

### Овог, аймгийн нэр.

1. Эхэд ىنونقآن *Anqunut* хэмээн бичжээ [102a, 14]. Гэвч Судрын чуулганд ىنونقآن *Olqunut* иргэнээс гаралтай түүний нэр нь Сандагжин.” хэмээн өгүүлсэн байдаг [Rešidüddin Fazlullah 1373. s.280]. Энд зохиогч дээрээ цэгтэй ن үсгийг ن үсгээр андуурч уншсан бололтой. Гэтэл И.Березин эхийг баримталж ямар нэгэн тайлбаргүй *Анкономъ* гэж бичжээ [Березнымъ1849. с. XXXV]. Харин Якуф Карасой, Мустафа Токер нар тус нэрийг *Ankunut* хэмээн бичээд дунд үеийн нэгэн монгол аймгийн нэр хэмээн тайлбар хийжээ [Karasoy, Toker. 2005. s. 77, 112]

2. Эхэд ىنچىروب *Borucqin* хэмээн бичсэн байна. Монголын нууц товчоонд тус нэрийг 孛兒只斤 *Borjigin* хэмээн бичсэн [§ 42] бол Судрын чуулганд ىنچىروب *Borjiqin* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.270]. И.Березин эхийг дагаж *Буругкчинъ* гэжээ [Березнымъ 1849. с. XXXIV].

3. Эхэд ىوىجبات *Tabciut* хэмээн бичжээ [103b, 104a]. Энд Судрын чуулганы ى үсгийн хоёр цэгийг нэг цэгтэй андуурч ب болгож уншсан бололтой. Тус нэрийг Судрын чуулганд ىوىچبات *Taiči'ut* хэмээн бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.186]. Монголын нууц товчоонд 泰赤

ᠯ<sub>揚</sub> *Taiči'ut* гэж бичсэн байдаг [§ 72]. И.Березин эхийг дагаж *Табджіюм* гэж бичсэн байна [Березнымъ 1849. с. XXXVI].

4. Эхэд *قانىلى Qanyli* хэмээн бичжээ [93b, 01]. Судрын чуулганд тус нэрийг *قانىلى Qanqli* гэж бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.52] бол Монголын нууц товчоонд тус нэрийг *康鄰 Kanglin* хэмээн тэмдэглэжээ [§ 270]. И.Березин тус нэрийг *Гконгголай* хэмээн уншжээ [Березнымъ 1849. с. XXIII].

5. Эхэд *گوجاغ Ayaciğ* хэмээн бичжээ [93b, 02]. Судрын чуулганд тус нэрийг *چاغ Ayacıeri* гэж бичжээ [Rešidüddin Fazlullah 1373. s.53]. Эхэд тус нэрийн *ر* үсгийг *و* үсэг хэмээн андуурсан, мөн *ع* үсгийг *گ* үсэгтэй андуурсан бололтой байна. И.Березин тус нэрсийг Уйгурь, Гконгголай, Гкыпчагъ, Ххаладжъ, Аггаджукъ зэргээр уншжээ [Березнымъ 1849. с. XXIII]. Якуф Карасой, Мустафа Токер нар ямар нэгэн тайлбаргүй эхийг дагаж *Uygurlar, Kanghlar, Kırçaklar, Halaçlar, Ağaçükler* хэмээн бичсэн байна [Karaso, Toker 2005. s. 69]

### Газар усны нэр

1. Эхэд *نوكىن Ozkenk qun* хэмээн тэмдэглэжээ [95b, 07]. Судрын чуулганд тус газрын нэрийг *نوكىن Erkene qun* хэмээн бичсэн байдаг [Rešidüddin Fazlullah 1373. s.147]. Тус сурвалжийн зохиогч Судрын чуулганыг ашигласнаа хэдэн удаа давтан өгүүлсэн байна. Тэгэхдээ Судрын чуулганд *نوكىن* үгийн *ر* [r] үсгийн дээрх богино дуудлагын тэмдэгтийг цэгтэй андууран *ز* [z] хэмээн уншсан нь илэрхий байна. И.Березин тус нэрийг “Узгене Гкон” хэмээн уншжээ [Березнымъ 1849. с. XXVI]. Энэ нэрийн хоёрдугаар бүтэц болох *نوكىن* хэмээх үгийг *qon* эсвэл *qun* гэж унших бүрэн боломжтой боловч Монголын нууц товчоон дахь *Jorqal-qun, Naqu-qun, Sariq-qun, Quldaqar-qun* зэрэг уулын нэрээс дуудлагыг нь сэргээн унших боломжтой юм.

2. Эхэд *انوان Otan* хэмээн бичжээ [96b, 07]. Энд *انوان Onan* хэмээх үгийг уншихдаа цэг андуурч уншсан нь тодорхой байна. Судрын чуулганы яг энэ өгүүлбэрт тус голын нэрийг *انوان Onan* хэмээн бичсэн [Rešidüddin Fazlullah 1373. s.219] бол Монголын нууц товчоонд *幹難 Onan* хэмээн бичдэг [§ 1]. И.Березин эхийг баримталж “Отана” хэмээн бичжээ [Березнымъ 1849. с. XXVII]. Эхэд буй “Нутаг нь Отан [Онон], Хэрлэн, Туул ажээ.” гэсэн өгүүлбэрийг Якуф Карасой, Мустафа Токер “Тэдний нутаг бэлчээр сайтай бөгөөд гэрүүд нь тоосгоор барьсан.” хэмээн буруу орчуулжээ [Karaso, Toker 2005. s. 72]. Тэд тус гурван голын нэрийг цагадай хэлний үг хэмээн ойлгожээ.

Шибани нāме сурвалжид гарч буй Монгол хэлний оноосон нэрүүдэд гарч буй алдаа, зөрчлийг дээрх хэдэн жишээнээс тоймлон үзвэл дараах нийтлэг алдаанууд ажиглагдаж байна.

1. Нэрийн ب үсгийг ى үсгээр, ى үсгийг ب үсгээр андуурсан
  - 1 ى ق ت ق ن و ق وى *yūqun qataqi*      ب ق ت ق ن و ق وى *buqun qataqi*
  - 2 ت وى ج بات *tabciut*      ت وى چ ا ت *taiči 'ut*
  
2. Нэрийн ر үсгийг و үсгээр андуурсан, و үсгийг ر үсгээр андуурсан
  - 1 و ح م ب و ق *quba hu merken*      ر م ر چ و ق *qoričar mergen*
  - 2 و ا غ و ب ن و ك و ا *ökin buyaq*      و ا ر ب ن و ك و ا *ökin barqaq*
  - 3 و ا م ب ا ت ر و ب *burta bahadır*      و ا ه ب ن ا ت ر ب *bartan bahadır*
  - 4 و ا ج و ا غ *ayacıg*      و ا چ ا غ *ayačeri*
  
3. Нэрийн ت үсгийг ن үсгээр, ن үсгийг ت үсгээр андуурсан
  - 1 ت ن و ا ن ا د و ت *tudan-oncikin*      ت ن و ا ن ا گ و ت *tydygen otčgin*
  - 2 ت ن و ا ن ا د و ت *dariny otcikfn*      ت ن و ا ن ا ت و ا د *daritay otčigin*
  - 3 ت ا ن و ا *otan*      ت ا ن و ا *onan*
  
4. Нэрийн ق үсгийг ت үсгээр, ت үсгийг ق үсгээр андуурсан
  - 1 ق و ا د و ب س و ق *qusbuda 'u*      ق و ا د و ب س و ت *tusbuda 'u*
  - 2 ق و ت و ق و ت *tutuqtu*      ق و ت و ق و ت *qutuqtu*
  
5. Нэрийн ق үсгийг ف үсгээр, ف үсгийг ق үсгээр андуурсан
  - 1 ق ن و ا ج و ق ن و ل و ا *öelün qocin*      ق ن و ا ج و ف ن و ل و ا *öelün füjin*
  - 2 ق ن و ا ج و ق ن و ل و ا *fücin biki*      ق ن و ا ج و ق ن و ل و ا *qocin biki*

Тодорхой хэлбэл, гар бичмэлд ойролцоо зурлагатай үсгүүдийг андуурсны зэрэгцээ хоорондоо нэг цэгийн ялгаатай бичигддэг үсэгнүүдийг андуурч уншсанаас үүдэлтэй алдаанууд нийтлэг байна. Тиймээс Аноним Шибани нāме-г Чингис хаан ба түүний өвөг дээдсийн нэрийн талаар өөр хувилбарыг өгч буй сурвалж гэж үзэх боломжгүй юм. Шибани нāме сурвалжийн зохиогч, хуулан бичигч нар перс сурвалжуудад байгаа монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг алдаж уншсан, түүний цэг дуслыг андуурсан алдаанууд гаргаснаас үүдэлтэй тус сурвалжийн судалгаанд зарим ойлгомжгүй байдлууд үүсэж, тодорхой бэрхшээл тулгардаг. Тэр дундаа Монголын түүх, монгол хүний нэрийн тогтолцоог сайн мэдэхгүй залуу судлаачдын



хувьд тодорхой бэрхшээл болдог. Тиймээс энэ сурвалжид тэмдэглэгдсэн монгол хүний нэр, газар усны нэр, овог аймгийн нэрийг Судрын чуулган болон Монголын нууц товчоонд гэх зэрэг сурвалжтай тулган нягтлаж алдааг нь засах, зөрүүтэй бичлэгүүдийг жигдлэх зайлшгүй шаардлагатай юм.

### Ашигласан материал

1. Ebu'l-Gazi Bahadır Han 2009: *Ebu'l-Gazi Bahadır Han Türk'ün Soy Ağacı Türk Şeceresi. Çağatay şivesinden Türkiye şivesine çeviren Rıza Nur. Günümüz Türkçesine Sadeleştiren Yunus Yiğit. İstanbul, 2009.*
2. Rachewilts 1972: *Rachewilts I.de. Index to the Secret History of the Mongols. Bloomington. 1972.*
3. Rashiduddin Fazlullah 1998: *Rashiduddin Fazlullah. Jami'ut-tawarikh: Compendium of Chronicles. English translation and Annotation by W.M.Thackston. Part one. Harvard University. 1998*
4. Grousset 1980: *Renü Grousset. Bozkır İmparatorluğu. İstanbul. 1980.*
5. ReşidüddinFazlullah1373:*Reşidüddin Fazlullah Hemedani. Свми'ut-tevbroh. Tashih Muhammed Рыşен ve Mustafa Мыsevo. С.І, Enteşerat-i Elborz, Tahran.1373.*
6. Karasoy, Toker 2005: *Yakup Karasoy, Mustafa Toker. Türklerde Şecere Geleneği ve Anonim Şibanînâme.Konya. 2005.*
7. Березнымъ 1849: *И.Березнымъ. Шейбанада. История монголо – тюрковъ. Джагатайскомъ диалектѣ, съ переводомъ, примѣчаниями и приложениями. Казань. 1849.*
8. [www.mnuuts.net](http://www.mnuuts.net)